


“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлын 2022 оны 4 дугаар
сарын 29-ны өдрийн
тогтоолын хавсралт



“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрэм нь “Тавантолгой төмөр зам” хязгаарлагдмал хариуцлагатай компани /цаашид “Компани” гэх/-ийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэл, удирдлагын бүтэц, тэдгээрийн эрх, үүргийг тодорхойлсон эрх зүйн үндсэн баримт бичиг /цаашид “Дүрэм” гэх/ мөн.

1.2. Компанийн оноосон нэр нь Монгол хэлээр “Тавантолгой төмөр зам” хязгаарлагдмал хариуцлагатай компани, товчилсон нэр нь “ТТЗ” ХХК, англи хэлээр “Tavantolgoi railway” Limited Liability Company, товчилсон нэр нь “TTZ” LLC байна.

1.3. Компанийн төрийн мэдлийн хувьцаа эзэмших эрхийг хэрэгжүүлэгч этгээд нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 304 дүгээр тогтоолд заасны дагуу “Эрдэнэс-Тавантолгой” ХК болон “Монголын төмөр зам” ТӨХК байна.

1.4. Компани нь “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн охин компани бөгөөд “Монголын төмөр зам” ТӨХК-ийн хараат компани байна.

1.5. Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх этгээд нь хуульд өөрөөр заагаагүй бол хувьцааг захиран зарцуулахаас бусад хувьцаа эзэмшигчийн эрхийг дүрэмд заасны дагуу хэрэгжүүлнэ. Хувьцаа захиран зарцуулах эрх зөвхөн Монгол Улсын Засгийн газарт хадгалагдана.

1.6. Компанийн оршин байгаа газрыг түүний ерөнхий захиргаа буюу Гүйцэтгэх удирдлага оршин байгаа газрын хаягаар тодорхойлох бөгөөд хаягийн өөрчлөлт гарсан тухай бүр улсын бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулна.


1.7. Компани нь бэлгэдэл (барааны тэмдэг)-тэй байхаас гадна хууль тогтоомжид заасны дагуу албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг, дардас хэрэглэнэ.

1.8. Тэмдэг, бэлгэдлийн загварыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл баталж, Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн байх бөгөөд тэдгээрийг хэрэглэх эрхийг зөвхөн Компани эдэлнэ.

1.9. Компанийн тэмдгийг гүйцэтгэх удирдлагын эрх олгосон этгээд хадгалж, зохих журмын дагуу хэрэглэнэ.

ХОЁР.Компанийн эрх зүйн байдал

2.1.Компани нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, банкинд харилцах данстай, өөрийн нэрээр эрх эдлэн, үүрэг хүлээдэг, өмчлөлдөө буюу өөрийн тусгайлсан хөрөнгөтэй, санхүүгийн тайлан гаргадаг, ашгийн төлөө бие даасан хуулийн этгээд мөн.



2.2.Хувьцаа эзэмшигч нь эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

ГУРАВ.Компанийн үндсэн зорилт, үйл ажиллагааны чиглэл

3.1.Компанийн үндсэн зорилт нь төмөр замын төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар Монгол улсын эдийн засгийг дэмжсэн аюулгүй тээвэр, логистикийн сүлжээг өргөжүүлэн зам, тээврийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулах, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөрөнгө оруулалтын өгөөж, ашигтай ажиллагааг хангахад чиглэнэ.

3.2.Компани тодорхой бус хугацаагаар үйл ажиллагаа явуулах бөгөөд дараах чиглэлээр үндсэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлнэ:

3.2.1.Төмөр замын суурь бүтэц барих;

3.2.2.Төмөр замын суурь бүтэц ашиглах;

3.2.3.Суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн засварлах;

3.2.4.Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх.

3.3.Компани Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын 3 дугаар зүйлийн 3.2.4.2-т заасан Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц барих төсөлд хөрөнгө оруулж бүтээн байгуулалтыг хийх ба энэ суурь бүтцийг ашиглаж төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэн явуулна.

3.4.Компани нь үйлдвэрлэл, үйлчилгээг төрөлжүүлж эрхлэх зорилгоор охин ба хараат компани үүсгэн байгуулж болно.

3.5.Компанийн эрхлэн явуулах үйл ажиллагаа дүрмийн 3.2-т зааснаар хязгаарлагдахгүй бөгөөд шинээр үйл ажиллагаа эрхлэн явуулахтай холбоотой шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл гаргана.

3.6.Компани нь тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа явуулах тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авч улсын бүртгэлд бүртгүүлсний дараа тухайн үйл ажиллагааг эрхэлнэ.


ДӨРӨВ.Компанийн хувьцаа, үнэт цаас, хувь нийлүүлсэн хөрөнгө

4.1.Компани нь энгийн хувьцаа, өрийн бичиг, хувьцаанд хамаарах үнэт цаас болон бусад төрлийн үнэт цаасыг гаргахдаа Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ.

4.2. Компанийн зарласан энгийн хувьцаа нь нэг бүр нь 2500 /хоёр мянга таван зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,403,820,000 /нэг тэрбум дөрвөн зуун гурван сая найман зуун хорин мянга/ ширхэг байна.

/Энэ хэсэгт Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан./

4.3.Компанийн нийт хувьцааны жаран зургаан (66) хувийг "Эрдэнэс-Тавантолгой" ХК, гучин дөрвөн (34) хувийг "Монголын төмөр зам" ТӨХК эзэмшинэ. Хөрөнгө оруулалтыг биет ба биет бус, мөнгөн хөрөнгөөр оруулж, оруулсан хөрөнгийн хэмжээгээр хувьцааг эзэмшинэ.



4.4.Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хөрөнгийн хэмжээ нь 2,040,479,750,000.00 /хоёр их наяд дөчин тэрбум дөрвөн зуун далан есөн сая долоон зуун тавин мянга/ төгрөг байх ба эргэлтэд гаргасан нийт 816,191,900 /найман зуун арван зургаан сая нэг зуун ерин нэгэн мянга есөн зуу/ ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ. Компанийн эргэлтэд гаргасан энгийн хувьцааг дараах байдлаар эзэмшинэ.

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувь	Хувьцааны нэрлэсэн үнэ	Эзэмшиж буй хувьцааны тоо	Хувь нийлүүлсэн хөрөнгө
1	"Эрдэнэс-Тавантолгой" ХК	66%	2,500₮	538,686,654	1,346,716,635,000.00
2	"Монголын төмөр зам" ТӨХК	34%	2,500₮	277,505,246	693,763,115,000.00
Нийт		100%	2,500₮	816,191,900	2,040,479,750,000.00

/Энэ хэсэгт Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 02 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./

4.5.Компанийн энгийн хувьцаа нэг бүр нь хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын нэг эрхтэй байна.

4.6.Монгол Улсын Засгийн газраас олгосон Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн онцгой эрх, уг төслийн зориулалтаар олгосон газар эзэмших эрхийг биет бус хөрөнгө оруулалтаар тооцож хувьцаа эзэмшигчид ижил тэнцүү хэмжээгээр хувьцааг эзэмшинэ.

4.7.Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт үндэслэн Компанийн тухай хуульд заасан хэлбэрээр өөрчилнө.

4.8.Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хувьцаанаас бусад төрлийн үнэт цаас гаргаж болно.

4.9.Компанийн хувьцаа эзэмшигч нь компанийн болон бусад хувьцаа эзэмшигчийн худалдах хувьцаа, түүнийг худалдан авах эрхийн бичиг болон тэдгээрт хөрвөх үнэт цаасыг гуравдагч этгээдэд санал болгох үнээр өөрийн эзэмшлийн хувьцааныхаа тоонд хувь тэнцүүлэн тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй.

4.10.Компанийн хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшлийн хувьцаа болон хувьцаанд хөрвөх үнэт цаасыг зөвхөн дараах хэлбэрээр захиран зарцуулж болно. Үүнд:

4.10.1.Монгол Улсын Засгийн газарт зарим хэсгийг нь ногдол ашгийн хэлбэрээр шилжүүлэх;

4.10.2.Өөрийн охин компанийг байгуулах замаар хөрөнгө оруулалт хэлбэрээр шилжүүлэх;

4.10.3.Бусад хувьцаа эзэмшигч болон түүний охин компанид гуравдагч этгээдэд санал болгох үнээр худалдах.

4.11.Компанийн хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын Засгийн газрын зөвшөөрөлгүйгээр өөрийн эзэмшиж байгаа хувьцаа болон хувьцаанд хөрвөх үнэт цаасыг гуравдагч этгээдэд худалдах, шилжүүлэхийг хориглоно.

4.12.Компанийн хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын Засгийн газрын зөвшөөрөлгүйгээр өөрийн эзэмшлийн хувьцааг бүхэлд нь буюу хэсэгчлэн барьцаалах, баталгаа өгөх, өөр бусад арга хэлбэрээр гуравдагч этгээдэд эрх өгөх буюу хувьцаагаар баталгаа гаргах эрхгүй.

ТАВ.Ногдол ашиг

5.1.Компани ногдол ашиг олгох асуудлыг Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

ЗУРГАА.Компанийн удирдлага

6.1.Компанийн удирдлага дараах бүтэцтэй байна:

6.1.1.Хувьцаа эзэмшигчдийн хурал;

6.1.2.Төлөөлөн удирдах зөвлөл;

6.1.3.Гүйцэтгэх удирдлага.

ДОЛОО.Хувьцаа эзэмшигчдийн хурал

7.1.Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд ээлжит ба ээлжит бусаар хуралдана.

7.2.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн (4) сарын дотор зарлан хуралдуулна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг шийдвэрлүүлэхээр ээлжит бус хурлыг Монгол Улсын Засгийн газар, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, эсхүл аль нэг Хувьцаа эзэмшигчийн саналаар зарлан хуралдуулах бөгөөд энэ тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь хувьцаа эзэмшигчидтэй зөвшилцөн хурлын товыг тогтоож, хуралдуулна.

7.3.Энэ зүйлийн 7.2-т заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахдаа Засгийн газраас хэлэлцүүлэхээр үүрэг, даалгавар болсон асуудлыг нэн даруй хэлэлцэнэ.

7.4. Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч дараах эрх, үүрэгтэй:

7.4.1.Хувьцаа эзэмшигчдийн хуралд таслах эрхтэй оролцох;

7.4.2.Компанийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж хувьцаа эзэмшигчийн эрх бүхий дээд удирдлагад оруулж шийдвэрлүүлэх;

7.4.3.Олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд хувьцаа эзэмшигчийн төлөөллийг хэрэгжүүлэх.

7.5.Хувьцаа эзэмшигчдийн хурал нь Компанийн тухай хуульд заасан бүрэн эрхээс гадна дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.5.1.Компанийн үйл ажиллагааны зориулалтаар зээл авах, баталгаа, батлан даалт гаргах эсэх асуудлыг шийдвэрлэх;

7.5.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам батлах;

7.5.3.Дүрэмд заасан Хувьцаа эзэмшигчийн эрх, үүрэгт хамаарах бусад асуудал.

7.6.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэхээр төлөөлж оролцох гишүүн нь хувьцаа эзэмшигчийн эрх бүхий удирдлагаас баталсан удирдамж, зааврыг баримтлан ажиллана.

7.7.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь төлөөлөн удирдах зөвлөлтэй компанийн хэтийн төлөвлөгөөг тохиролцож, түүний хэрэгжилтийг хянаж, дүгнэхээс бусад хэлбэрээр өдөр тутмын удирдлагын үйл ажиллагаанд оролцохгүй.

7.8.Компанийн хувьцаа эзэмшигч нь ногдол ашгийн хувь хэмжээг тогтоох саналыг Төлөөлөн удирдах зөвлөлд бичгээр гаргана.

НАЙМ. Төлөөлөн удирдах зөвлөл

8.1.Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна.

8.2.Төлөөлөн удирдах зөвлөл нь нийт есөн (9) гишүүнтэй байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас хоёр (2) жилийн хугацаагаар сонгох бөгөөд дахин сонгох, хугацаанаас нь өмнө чөлөөлж болно.

8.3.Компанийн хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшиж байгаа хувьцааныхаа тоонд хувь тэнцүүлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд хувьцаа эзэмшигчийг төлөөлөх гишүүнийн нэрийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороонд санал болгох бөгөөд нэр дэвшүүлэх хороо нь тэрхүү нэр дэвшигдэж байгаа этгээд нь хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчийг төлөөлөх этгээд мөн бол Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилуулахаар хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд оруулах үүрэгтэй.

8.4.Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуульд заасан бүрэн эрхээс гадна дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:



8.4.1.компанийн урт, дунд хугацааны стратеги төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

8.4.2.компанийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг хянаж батлах, тайланг дүгнэх;

8.4.3.компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоох;

8.4.4.охин, хараат компани байгуулах, хөрөнгө оруулалт хийх, оруулсан хувь хөрөнгөө татан авах;

8.4.5.шинээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх асуудлыг шийдвэрлэх;



8.4.6.хувьцаа эзэмшигчдийн эрх барих дээд байгууллагын саналыг үндэслэн ногдол ашиг хуваарилах эсэхийг шийдвэрлэх, ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тодорхойлох;

8.4.7.компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг батлах.

8.5.Төлөөлөн удирдах зөвлөл нь хууль болон дүрэмд заасан тайлан, бусад мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд хугацаанд нь гаргаж өгөх үүрэгтэй.

8.6.Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд байнгын орон тоотой ажлын албатай байж болох бөгөөд Ажлын албаны дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга байна. Ажлын албаны орон тоо, ажиллах журмыг Төлөөлөн удирдах зөвлөл батална.

ЕС.Гүйцэтгэх удирдлага

9.1.Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

9.2.Гүйцэтгэх захирал нь Компанийн тухай хууль болон дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан контрактад заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийн эрх ашгийг дотооддоо болон хилийн чанадад төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

9.3.Гүйцэтгэх захирлын цалин хөлс, ээлжийн амралтын асуудлыг Хөдөлмөрийн тухай хууль болон Конрактын гэрээгээр зохицуулна.

9.4.Гүйцэтгэх захирлын дэргэд түүнд зөвлөх чиг үүрэг бүхий Захирлын зөвлөл ажиллана. Захирлын зөвлөлийн ажиллах журмыг Гүйцэтгэх захирал батална.

9.5.Гүйцэтгэх захирал нь Компанийн тухай хуульд зааснаас гадна дор дурдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

9.5.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн өмнө Компанийн үйл ажиллагааг хариуцаж, жилд 1-ээс доошгүй удаа ажлын үр дүнг тайлагнах;



9.5.2.санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, тэнцлийг цаг тухайд нь гаргаж, холбогдох этгээдэд тайлагнах, мэдээлэх, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах;

9.5.3.Компанийн нэр хүнд, ашиг, орлого, хувьцаа эзэмшигчийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, санхүү болон бусад үйл ажиллагааг алдагдал, эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх, бууруулахад чиглэсэн удирдлагын оновчтой менежментийг нэвтрүүлэх;

9.5.4.батлагдсан төсөв, хөрөнгийг өөрт олгогдсон эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулах;

9.5.5.Компанийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах;

9.5.6.ажлын байрын тодорхойлолт боловсруулж батлах, ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх, цуцлах, дуусгавар болгох;



9.5.7. батлагдсан төсвийн хүрээнд албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн сүлжээг баталж мөрдөх;

9.5.8. Компани болон салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны хөдөлмөрийн дотоод журам, тэдгээрт нийцсэн бусад дүрэм, журмыг батлаж мөрдүүлэх;

9.5.9. хууль, дүрэм, контрактад заасан бусад эрх, үүрэг;

9.6. Гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон зөвшөөрлийн дагуу зарим эрх, үүргээ итгэмжлэлийн үндсэн дээр Компанийн холбогдох албан тушаалтанд шилжүүлж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

АРАВ. Салбар, төлөөлөгчийн газрын зохицуулалт

10.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр холбогдох хууль тогтоомжийн дагуу салбар, төлөөлөгчийн газрыг Монгол Улсад болон бусад /гадаад/ улсад байгуулж болно.

10.2. Салбар нь компанийн үндсэн үйл ажиллагааг түүний нэрийн өмнөөс өөр газар, нутагт явуулдаг этгээд байна. Төлөөлөгчийн газар нь компанийн нэрийн өмнөөс түүнийг төлөөлөн үйл ажиллагаа явуулна.

10.3. Салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй бөгөөд компаниас баталсан журмын дагуу үйл ажиллагаагаа эрхлэн явуулах ба Компанийн албан ёсны хэвлэмэл хуудас, салбар, төлөөлөгчийн газрын тэмдэг хэрэглэнэ.

10.4. Салбар, төлөөлөгчийн газрын захирал нь Гүйцэтгэх захирлаас олгосон итгэмжлэлийн үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна.

АРВАН НЭГ. Компанийн эрх бүхий албан тушаалтан

11.1. Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1-д нэрлэн зааснаас гадна зохион байгуулалтын бүтэцтэй уялдуулан эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг Дүрэмд нийцүүлэн Гүйцэтгэх захирал батална.

11.2. Компанийн эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага, түүний хэмжээг тогтоох асуудлыг хууль тогтоомж, Дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээ, хөдөлмөрийн гэрээ, Компанийн дотоод журмаар тогтоох бөгөөд байгуулсан гэрээ, тэдгээрийн дагуу шийдвэрлэх боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

11.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хуулийн 84 ба 85 дугаар зүйлд зааснаар үүрэг, хариуцлага хүлээнэ.

АРВАН ХОЁР. Компанийн хяналтын тогтолцоо

12.1. Компанийн хяналтын тогтолцоо нь дараах бүтэцтэй байна.


12.1.1. хувьцаа эзэмшигчдийн хяналт;

12.1.2. хөндлөнгийн аудит;

12.1.3. дотоод хяналт.

12.2.Хувьцаа эзэмшигчдийн хяналтыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо хэрэгжүүлнэ.

12.3.Аудитын хороо нь Дүрэм, Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, компанийн удирдлагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гарган, үйл ажиллагаагаа Төлөөлөн удирдах зөвлөл болон Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.



12.4.Аудитын хороо нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг хянан шалгахдаа дүрэм болон холбогдох хуулиар олгогдсон эрхийг эдэлнэ.

12.5.Санхүүгийн болон гүйцэтгэлийн хөндлөнгийн аудитыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс сонгосон тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагаар ээлжит ба ээлжит бусаар хийлгэнэ.

12.6.Ээлжит хөндлөнгийн аудит нь компанийн жилийн санхүүгийн тайланг хянан баталгаажуулна.

12.7.Хөндлөнгийн аудитын тайланг Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулна.


12.8.Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг дотоод аудитын нэгж, албан тушаалтан хэрэгжүүлнэ. Гүйцэтгэх захирлын баталсан Дотоод хяналтын журмын дагуу үйл ажиллагаагаа явуулна.

12.9.Дотоод хяналт нь шалгалтаар илэрсэн алдаа, зөрчил, дутагдлыг арилгах, компанийн хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн дүгнэлт, зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад өгч, Гүйцэтгэх захиралд танилцуулах, мэдээлэх үүрэгтэй.

АРВАН ГУРАВ.Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл

13.1.Их хэмжээний хэлцэл гэж тухайн хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцлийг хэлэх бөгөөд түүнийг Компанийн тухай хуулийн 87 ба 88 дугаар зүйлд заасан журмын дагуу хийнэ. /Компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй./

13.2.Сонирхлын зөрчилтэй хэлцэл гэж эрх бүхий албан тушаалтан болон тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн компанитай хийж байгаа аливаа хэлцлийг хэлэх бөгөөд түүнийг Компанийн тухай хуулийн 89, 91, 92 дугаар зүйлд заасан журмын дагуу хийнэ.



АРВАН ДӨРӨВ.Компанийн нягтлан бодох бүртгэл, тайлан

14.1.Компани нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй байна. Энэхүү баримт бичгийг Төлөөлөн удирдах зөвлөл батална.

14.2.Компани нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан Хувьцаа эзэмшигчдийн хурал болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулах бөгөөд

санхүүгийн тайлангийн үнэн зөвийг компанийн Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч хариуцна.

14.3.Компани нь хөндлөнгийн аудитын дүгнэлт гаргуулсны дараа жилийн санхүүгийн тайлан, ашиг, алдагдлын тайланг Хувьцаа эзэмшигчдийн хурал болон холбогдох хууль тогтоомжид заасан эрх бүхий этгээдэд танилцуулна.

АРВАН ТАВ. Компанийн бичиг, баримтыг хадгалах

15.1.Компани нь дараах бичиг баримтыг хадгалах үүрэгтэй:

15.1.1.Компанийн дүрэм, Дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулга, компанийг байгуулах тухай үүсгэн байгуулагчдын хурлын шийдвэр, компанийн бүртгэлийн гэрчилгээ;

15.1.2.Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагаас баталсан тогтоол, шийдвэр, тушаал, дүрэм, журам компанийн дотоод баримт бичиг;

15.1.3.нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт бичиг;

15.1.4.Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагын зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр, тогтоол, Компанийн гүйцэтгэх захирлын тушаал, байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй бусад гэрээ, түүний биелэлттэй холбогдох баримт бичиг;

15.1.5.Ажилтны ажлын байрны тодорхойлолт, контракт, хөлсөөр ажиллах болон хөдөлмөрийн гэрээ;

15.1.6.Аудитын дүгнэлт;

15.1.7.хувьцаа болон үнэт цаас гаргах журам;

15.1.8.эрх бүхий албан тушаалтан болон нийт ажиллагсад олгосон цалин, шагнал, урамшуулалттай холбоотой бичиг баримт;

15.1.9.компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн нэрсийн жагсаалт болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны төрөл, тоо; санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан;

15.1.10.бусад баримт бичиг;


15.2.Компани нь өөрийн дүрэм, түүнд орсон нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг байнга хадгална. Бусад баримт бичгийг 5 жилийн хугацаатай хадгалах, баримт бичгийн хугацаа дууссаны дараа архивт шилжүүлнэ.

15.3.Хувьцаа эзэмшигчдийн хурал компанийн хувьцаа болон үнэт цаас гаргах, компанийн дүрэм, түүний нэмэлт, өөрчлөлттэй холбогдол бүхий баримт бичгийг хүлээн авах, хадгалах, танилцуулах, архивт шилжүүлэх ажиллагааг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга эрхлэн гүйцэтгэнэ.

АРВАН ЗУРГАА. Компанийг татан буулгах

16.1.Компанийг Иргэний хууль болон бусад холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр татан буулгана.

16.2.Татан буулгах комисс томилогдсоноор Компанийн Гүйцэтгэх захирлын бүрэн эрх дуусгавар болж, татан буулгах комисст шилжинэ.



АРВАН ДОЛОО. Бусад

17.1.Дүрэмд тусгагдаагүй асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

17.2.Дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болох бөгөөд үндсэн эхийг Компани хадгална.



---oOo---